

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.04.18

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,047.2	0.867%	6.957%	6.919%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.867 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банкнаас интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаагаас ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 214.3 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг нэг ханшаар нийлүүлсэн байна. Банкнуудаас 11 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах санал ирүүлснээс Монголбанк 2 сая ам.доллартай тэнцэх хэлцлийг биелүүлсэн байна.

**Гадаад худалдаа:**

2022.03 сард Монгол Улсын гадаад худалдаа 109 сая ам.долларын ашигтай гарснаар цэвэр экспорт 251.3 сая ам.долларт, бараа эргэлт 1.41 тэрбум ам.долларт хүрсэн байна. Гадаад худалдааны тэнцэл эерэг гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	99.98	0.18%	1.68%	9.53%
EURUSD	1.0797	-0.79%	-2.33%	-10.27%
USDCNY	6.3723	0.12%	0.2%	-2.07%
USDRUB	79.99	1.18%	-23.68%	4.76%
USDJPY	126.6	1.01%	6.24%	17.07%
AUDUSD	0.7362	-0.78%	-0.73%	-5.11%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэрэг чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын 3 сарын Хэрэглээний Үнийн Индексийн тоон мэдээлэл гарсан бөгөөд өнгөрсөн жилээс 8.5 хувиар, өнгөрсөн сараас 1.2 хувиар өссөн байна. Харин эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүнийдийг хассан өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ өмнөх оноос 6.5 хувиар өссөн бол өмнөх сараас 0.3 хувиар өсжээ. Ингэснээр АНУ-ын инфляцын түвшин 40 жил дэх хамгийн өндөр түвшиндээ хүрээд байна. Энэ нь АНУ-ын ХНС бодлогын хүүгээ эрс чангаруулах, цаашилбал ам.долларын ханш бусад улын валютын эсрэг чангарах нөхцөл байдал үүслээ.
- Өнгөрсөн пүрэв гарагт АНУ-ын жижиглэн худалдааны тоон мэдээлэл гарсан бөгөөд өнгөрсөн оноос 6.88 хувиар өсжээ. Жижиглэн худалдаа буурч байгаа нь өргөн хэрэглээний барааны үнэ өндөр, мөн хадгаламжийн хүү өсөж байгаатай холбоотой өсөлт саарч байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 18/Apr/2022 - 4:08:59 GMT. Powered by TradingView.
US Dollar Index, United States, NYSE:DXY, D



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.